




**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ. ДЭЛҮҮН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
БАРИГДАХ 2.5км АВТО ЗАМЫН ЗУРВАС ТАЛБАЙН ИНЖЕНЕР-
ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ**



БАРИЛГЫН ИНЖЕНЕР ХАЙГУУЛЫН
“ЭЛ ЭМ ЛАНД” ХХК

ЗТ42-869/19

Архив №016/022



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ. ДЭЛҮҮН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
БАРИГДАХ 2.5км АВТО ЗАМЫН ЗУРВАС ТАЛБАЙН ИНЖЕНЕР-
ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

/Ажлын зургийн шатанд зориулав/

Батлав:

ЗАХИРАЛ:

Хянасан:

АХЛАХ ИНЖЕНЕР:

Боловсруулсан:

ИНЖЕНЕР ГЕОЛОГИЧ:



З.БАХБЕРГЕН

Ж.ЖАНИБЕК

К.МЕШИТХАН

Хаяг: БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ӨЛГИЙ СУМ
1-р БАГ, Жылхышы Анэж-Од 2 давхарт 3 тоот
Утас: 91916187; 95661888

IV. ТОВЧ ДҮГНЭЛТ

1. Судалгааны зурвас талбай нь геоморфологийнхоо хувьд уулс хоорондын хөндийд байрлах бөгөөд авто замын 2 трассын дагууд баруун урдаас зүүн хойшоо намссан, баруун хойноос зүүн урагшаа намссан хэвгий тогтоцтой, судалгааны талбайд 5 төрлийн элемент илэрсэн, газрын хэвгийг дагаж гадаргуугийн болон шугаман угаагдал хүчтэй явагдах нөхцөлтэй, газар хөдлөлийн VIII (500 жил) баллын бүсэд оршдог зэргээс хамаарч инженер-геологийн төвөгшлийн ангилалаар дүнд зэргийн нөхцөлтэй талбайд хамаарагдаж байна.
2. Судалгааны зурвас талбайд 4.5-6.0м гүнтэй 7 цооног өрөмдөхөд газар доорхи ус илрээгүй. /2022 оны 04-р сарын 20-22-ны өдрүүдийн байдлаар/
3. Судалгааны район нь Монгол орны цэвдгийн тархалтын зураг /M1:1000000/-аас харахад тохиолдлын тархалттай бүслүүрт багтаж байгаа нь харагдах боловч судалгааны зурвас талбайд 6.0м гүн өрөмдлөгөөр /2022 оны 04-р сарын 20-22-ны өдрүүдийн байдлаар/ ОЖЦ хөрс тохиолдоогүй байна.
4. Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл АЗУАГН.01.01-2004 –н дагуу буурь хөрсний механик шинж чанарын норматив тооцооны үзүүлэлтүүдийг хүснэгтэд үзүүлэв

Хүснэгт IV-1

ИГЭ-ийн дугаар	Хөрсний нэр төрөл	Автозамын ажлын үед ашиглагдах хөрсний ангилал /27-р хүснэгт/	Замын холбоослог болон холбоослог бус ул хөрсний тооцооний үзүүлэлтүүд /19-20-р хүснэгт/			Хөрсний хөдөлтийн норматив гүн /46-р хүснэгт/	Хөлдөх үеийн овойлтын /31-р хүснэгт/		
			Е _{хөрс} МПа	Ф _{хөрс} град	С _{хөрс} МПа		IV	Хөрсний бүлэг	Овойлтын зэрэг
ИГЭ-1	Хайрга агуулсан жижиг ширхэгтэй элс	Нарийн ширхэглэлтэй элс	100	38	0,005	3,0	II	Сул овойлттой	1-4
ИГЭ-2	Хайргархаг элс	Хайргархаг том ширхэглэлтэй	130	42	0,005	3,2	I	Овойлтгүй	≤1
ИГЭ-3	Элсэн чигжээстэй хайрга	Хайргархаг том ширхэглэлтэй	130	42	0,005	3,5	I	Овойлтгүй	≤1
ИГЭ-4	Хайргархаг элсэнцэр	Хайргархаг хөнгөн элсэнцэр	70	37	0,015	3,0	III	Овойлттой	4-7

Зураг төсөл, судалгаа шинжилгээний “Эл Эм Ланд” ХХК

ИГЭ-5	Элсэнцэр чигжээстэй хайрга	Хайргархаг том ширхэглэлтэй	130	42	0,005	3,5	II	Сул овойлттой	1-4
-------	----------------------------	-----------------------------	-----	----	-------	-----	----	---------------	-----

5. Ул хөрсний газар шорооны ажлын зэрэг болон хувийн цахилгаан эсэргүүцлийн утгыг доорхи хүснэгтээр үзүүлээ.

Хүснэгт IV-2

ИГЭ-ийн дугаар	Хөрсний нэр	Газар шорооны ажлын зэрэг	Хувийн цахилгаан эсэргүүцэл, ом.м
ИГЭ-1	Хайрга агуулсан жижиг ширхэгтэй элс	I	Хуурай нөхцөлд: 2000-10000 Устай нөхцөлд: 200-600
ИГЭ-2	Хайргархаг элс	III	
ИГЭ-3	Элсэн чигжээстэй хайрга	IV	Хуурай нөхцөлд: 2000-10000 Устай нөхцөлд: 300-800
ИГЭ-4	Хайргархаг элсэнцэр	III	80-200
ИГЭ-5	Элсэнцэр чигжээстэй хайрга	IV	120-600

6. Төлөвлөж буй байгууламжийн талбайн газар хөдлөлийн VIII (500 жил) баллын бүсэд хамаарагдаж байна. [3] Хөрсний оргил хурдатгал (XOX) 182-202см/с² байна.

Зөвлөмж:

1. Байгууламжийн ажлыг гүйцэтгэхдээ Монгол улсад мөрдөгдөж байгаа Барилгын газар шороо буурийн ажил “БНБД 50-02-17” нормын заалтуудыг мөрдлөг болгож суурийн ажлыг хийж дуусгах нь зүйтэй.
2. Судалгааны зурвас талбайд хур бороо элбэгтэй улиралд гадаргуугийн болон шугаман угаагдал хүчтэй явагдах нөхцөлтэй, жижиг ширхэгтэй элс болон элсэнцэр хөрсүүд сулавтар овойлт үүсгэх тул шугаман байгууламжийн суурийг ус чийгнээс хамгаалах арга хэмжээ авах.

Дүгнэлт, зөвлөмж бичсэн инженер-геологич:

Kelly

/К.Мепитхан/

